



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/268

Мөрөн сум

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3, Тамхины хяналтын суурь конвенцийн 1 дүгээр зүйлийн е, 4 дүгээр зүйлийн 4, 5 дугаар зүйлийн 2.6, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 2 дугаар зүйлийн 3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.9, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 94 дүгээр зүйлийн 94.1, Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн I хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тамхины хэрэглээ, никотины дасал түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд 18 нас хүрээгүй хүнд утаат болон электрон тамхи түний дагалдах хэрэгслийг худалдаалах, 18 нас хүрээгүй хүнээр тамхи худалдан борлуулах, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат болон электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг тус тус хориглосугай.

2. Холбогдох хууль тогтоомж болон захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хамтран ажиллахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (А.Алтанцоож), аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6717010336